



## “МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 3-р сарын 14 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай

1. Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг хуралдуулах хугацааг товлдох,
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг батлах,
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг сонгох,
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах комиссыг батлах
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссыг томилох ,  
ШИЙДВЭРЛЭХ НЬ :

Нэг. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 11 цагт өөрийн байранд хуралдуулсугай.

Хоёр . Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

1. Өнгөрч буй 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн эцсийн тайлангийн талаар ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хэлэлцэх,

2. Тус компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд , “Шинэ их тэрбум аудит” ХХК –ийн хийсэн дүгнэлтийг сонсож хэлэлцэх,

3. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдахаар зарлагдсан улсын болон орон нутгийн чанартай сонгон шалгаруулалтад оролцох шаардагдах төсөв ,төлөвлөгөө ,зардлыг бодитой тооцож тухайн цаг үед нь уялдуулан ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэх ,

4. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах , ажлын байр нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөх ,

5. ХУД-ийн 12-р хорооны нутагт байрлах компанийн эзэмшлийн 8,08 га газарт үйлдвэрлэлийн зорилгоор ашиглах төсөл төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, түүнчлэн тус газрыг түрээслүүлэх байдлаар үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх удирдлагад даалгах,

6. Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт, мөнгөний ханшийн уналт, инфляцийн тогтворгүй байдалтай уялдуулан “Мон-Гео” ХК-ийн дүрмийн 8.5.1 дэх заалтыг өнөө үетэй зохицуулах замаар өөрчлөн найруулж, шинэчлэн батлах,

7. Компанийн санхүүгийн байдлыг тогтвортой , үр дүнтэй , үр өгөөжтэй болгохоор бизнес төлөвлөгөө, төслийг боловсруулан 2026-2030 онуудад хэрэгжүүлэх,

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга Н.Соёмбыг томилсугай.

Дөрөв . Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга : - Х.Анар

Комиссын нарийн бичгийн дарга : - Н.Тулга

Тав.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай. Үүнд :

Тооллогын комиссын дарга – Ц.Алтансүх

Тооллогын комиссын гишүүн – Г.Даваажаргал , Б.Түмэнжаргал

Зургаа.Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг хуралдуулах тухай мэдэгдэх өдрийг 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдөр 2026 оны 04 дүгээр сарын 7-ны өдөр байхаар шийдвэрлэсүгэй.

Долоо. Нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр байхаар шийдвэрлэсүгэй.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах зохион байгуулалтын ажиллагаанд “компанийн тухай хууль” –ийн 59.8 , 59.9 дэхь заалтуудыг хэрэгжүүлж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын дарга /Х.Анар /-д зөвшөөрсүгэй.

ТУЗ-ийн дарга ..... / Н.Соёмбо /

